

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр

№ 25/16





Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн ТУЗ-ийн даргаар Очирсүрэн овогтой Болдбаатар (РД:ЙЮ80100817)-ыг сонгосугай.
2. Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн дүрэм, Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон холбогдох бусад хууль тогтоомж, баримт бичгийг мөрдөж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн дарга (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.
3. Компанийн ТУЗ-ийн дарга сонгогдсоныг Компанийн болон Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж, Санхүүгийн Зохицуулах Хороонд мэдэгдэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр), Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

	/О.БОЛДБААТАР/		/Ц.УУГАНБАЯР/
	/С.ЭНХ-АМГАЛАН/		/Б.ХОС-ЭРДЭНЭ/
	/Ж.ЖАРГАЛСҮРЭН/		/С.НЭРГҮЙ/
	/С.БӨРГИЛ/		/К.МАДОНО/
	/Ц.ОДМАА/		



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 дугаар сарын 09-ний одор

№ 25/17

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн даргын 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн санал, Компанийн ТУЗ-ийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Батсүлд овогтой Оюунболд (РД:)-ыг томилсугай.
2. Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн дүрэм, Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, холбогдох бусад хууль тогтоомж, баримт бичгийг мөрдөж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Б.Оюунболд)-д үүрэг болгосугай.
3. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга томилогдсоныг Компанийн болон Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж, Санхүүгийн Зохицуулах Хороонд мэдэгдэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр), Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Б.Оюунболд) нарт үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр

№ 25/18

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын
бүрэлдэхүүнийг батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 14 дүгээр зүйл, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг дор дурдсанаар баталсугай. Үүнд:

1.1. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл ба БОНЗ-ын удирдлагын хороо:

Хорооны дарга: ТУЗ-ийн Хараат бус гишүүн С.Нэргүй;

Гишүүд: ТУЗ-ийн Ердийн гишүүн Б.Хос-Эрдэнэ;

ТУЗ-ийн Ердийн гишүүн Ц.Ууганбаяр;

ТУЗ-ийн Ердийн гишүүн Кацухико Мадоно;

ТУЗ-ийн Ердийн гишүүн С.Энх-Амгалан.

1.2. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо:

Хорооны дарга: ТУЗ-ийн Хараат бус гишүүн Ж.Жаргалсүрэн;

Гишүүд: ТУЗ-ийн Хараат бус гишүүн С.Боргил;

ТУЗ-ийн Ердийн гишүүн Ц.Одмаа.

1.3. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх хороо:

Хорооны дарга: ТУЗ-ийн Хараат бус гишүүн С.Боргил;

Гишүүд: ТУЗ-ийн Хараат бус гишүүн Ж.Жаргалсүрэн;

ТУЗ-ийн Ердийн гишүүн О.Болдбаатар.

1.4. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо:

Хорооны дарга: ТУЗ-ийн Хараат бус гишүүн С.Нэргүй;

Гишүүд: ТУЗ-ийн Хараат бус гишүүн С.Боргил;

ТУЗ-ийн Ердийн гишүүн Ц.Одмаа.

2. Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн дүрэм, Компанийн үйл ажиллагааны журам, холбогдох бусад хууль тогтоомж, баримт бичгийг мөрдөж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Компанийн болон Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсанд байршсан мэдээлэлд өөрчлөлт оруулан олон нийтэд мэдээлж, Санхүүгийн Зохицуулах Хороонд мэдэгдэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр), Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Б.Оюунболд) нарт үүрэг болгосугай.



ТУЗ-ийн ДАРГА

О.БОЛДБААТАР

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр

№ 25/19

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны ээлжит хурлын хуваарь батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн 2025 оны ээлжит хурлын хуваарийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасны дагуу Компанийн ТУЗ-ийн ээлжит хурлыг тогтоосон хугацаанд хуралдуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Б.Оюунболд)-д, түүнд хяналт тавьж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн дарга (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр

№ 25/20

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын болон сургалтын төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.23 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээний тайлангийн үүрэг даалгаврыг биелүүлэх ажлын хүрээнд Компанийн ТУЗ-ийн 2025 оны Ажлын төлөвлөгөөг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр, ТУЗ-ийн 2025 оны Сургалтын төлөвлөгөөг энэхүү тогтоолын Хавсралт №2-оор тус тус баталсугай.
2. Энэхүү тогтоолын хавсралтуудаар батлагдсан төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлж, Компанийн ТУЗ-ийн төлөвлөгөөт ажил болон холбогдох сургалтыг зохион байгуулах, хамрагдсан сургалтын талаар Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнахыг Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Б.Оюунболд)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр

№ 25/21

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Тогтвортой байдлын бодлого болон Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ын зорилгод нийцүүлэн, Компанид засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг нэвтрүүлэх зорилтын хүрээнд Компанийн ТУЗ-ийн 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 24/17 тоот тогтоолоор батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1-г заасны дагуу нэмэлт, өөрчлөлт орж буй “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг энэхүү тогтоолын Хавсралт №1-аар баталсугай.
3. Энэхүү тогтоолын Хавсралт №1-аар батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, дагаж мөрдөхийг Компанийн ТУЗ-ийн нийт гишүүд, Компанийн эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг болгосугай.
4. Энэхүү нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх холбогдох бусад бодлого, дүрэм, журам, зааврыг түүнд нийцүүлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд өөрчлөлтийн саналыг Компанийн ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Б.Оюунболд)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр

№ 25/22

Улаанбаатар хот

Компанийн 2025 оны эх үүсвэрийн төлөвлөгөөг өөрчлөн батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 25/05 тоот тогтоолоор батлагдсан “2025 оны эх үүсвэрийн төлөвлөгөө”-г энэхүү тогтоолын хавсралтаар өөрчлөн баталсугай.
2. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан Компанийн 2025 оны эх үүсвэрийн төлөвлөгөөнд заасан хэмжээ, нөхцөлийн хүрээнд өрийн бичиг гаргах, хөрөнгө итгэмжлэн удирдах, бусад арилжааны эх үүсвэр татах, түүнтэй холбоотой гэрээ, хэлцэл байгуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан Компанийн 2025 оны эх үүсвэрийн төлөвлөгөөнд заасан хэмжээ, нөхцөлийн хүрээнээс давсан болон хоердогч эх үүсвэрийн санал, Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу тогтоосон их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хууль тогтоомжид заасан журмын дагуу Компанийн ТУЗ-өөр батлуулсны үндсэн дээр байгуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
4. Компанийн 2025 оны эх үүсвэрийн төлөвлөгөөний гүйцэтгэл, татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн талаарх мэдээллийг Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд тогтмол тайлагнаж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр

№ 25/23

Улаанбаатар хот

**Зээлээр эх үүсвэр татан төвлөрүүлэх,
гэрээ байгуулах эрх олгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4, 9.6.23 дахь заалтууд, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”) -ийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн зүгээс өөрийн зээлийн бүтээгдэхүүнүүдийн цар хүрээг тэлэх, харилцагчдынхаа осон нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангаж, санхүүгийн зах зээлд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, санхүүгийн байгууллагаас эх үүсвэр татан төвлөрүүлэх үйл ажиллагааг 2023 оноос эхлэн хэрэгжүүлж буйг дурдсугай.
2. Улмаар Компани нь хөрөнгө оруулалтын платформын үйл ажиллагаа эрхэлдэг “KILDE Pte.Ltd.” (цаашид “Kilde” гэх)-аар төлөөлүүлсэн олон улсын хөрөнгө оруулагчид (цаашид “Санхүүжүүлэгч тал” гэх)-аас нэг удаад 500,000 ам.доллар хүртэлх үнийн дүнтэйгээр, нийт 4,000,000 ам.доллар хүртэлх үнийн дүн бүхий санхүүжилт (цаашид “Санхүүжилт” гэх)-ийг зээлийн гэрээ (цаашид “Зээлийн гэрээ” гэх) байгуулах замаар татан төвлөрүүлэх тохиролцоонд хүрсэн болохыг тэмдэглэсүгэй.
3. Санхүүжилт татан төвлөрүүлэх үйл ажиллагааг баталгаажуулах хүрээнд Компаниас дор дурдсан санал ирүүлсэнтэй танилцаад:
 - 3.1. Санхүүжүүлэгч тал буюу ALT INCOME INVESTMENTS LMN1 PTE.LTD-тэй Зээлийн гэрээ байгуулах;
 - 3.2. Санхүүжүүлэгч талтай байгуулсан Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгон ALT INCOME INVESTMENTS PTE.LTD (цаашид “Төлөөлөгч” гэх)-тай Барьцааны гэрээ байгуулж, Санхүүжүүлэгч талын өмнө хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулахаар барьцаалуулагчийн үүрэг хүлээх;
 - 3.3. Санхүүжүүлэгч тал нь Санхүүжилтийг эргэн төлүүлэх үйл ажиллагаа, Барьцааны гэрээний эрх, үүргээ өөрийн нэрийн өмнөөс хэрэгжүүлэх Төлөөлөгч томилох хүсэлтэй байгаа тул Төлөөлөгч болон Санхүүжүүлэгч талтай Төлөөллийн гэрээ байгуулах;

(цаашид хамтад нь “Гэрээний багц” гэх)
шаардлагатай байгааг тус тус тэмдэглэсүгэй.

4. Тус тогтоолын 3-т заасан Гэрээний багцыг Санхүүжилт татан төвлөрүүлэх бүрд байгуулах шаардлагатай тул:
- 4.1. Нийт Санхүүжилтэд баримтлах нөхцөлийг Хавсралт №1А-д зааснаар баталсугай.
 - 4.2. Санхүүжилт тус бүрд байгуулах Зээлийн гэрээний нөхцөлийг Хавсралт №1Б-д зааснаар баталсугай.
 - 4.3. Санхүүжилт тус бүрд байгуулах Төлөөллийн гэрээ нөхцөлийг Хавсралт №1В-д зааснаар баталсугай.
 - 4.4. Санхүүжилт тус бүрд байгуулах Барьцааны гэрээний нөхцөлийг Хавсралт №1Г-д зааснаар баталсугай.
5. Тус тогтоолын хавсралтаар батлагдсан Гэрээний багцыг байгуулах замаар тухай бүр Санхүүжилт татан төвлөрүүлэхийг Компанид зөвшөөрсүгэй.
6. Гэрээний багцад багтаж буй гэрээ, түүнчлэн эдгээртэй дагалдах бусад гэрээ, хэлцлийг холбогдох талуудтай эцэслэн тохиролцож байгуулах, Багц гэрээний дагуу аливаа баримт бичиг үйлдэх, тэдгээрт гарын үсэг зурж баталгаажуулах, эдгээртэй холбогдох шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
7. Гэрээний багцыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тус багцад багтаж буй аливаа гэрээ, хэлцэлд дурдсан зөвшөөрөл, хүсэлт, мэдэгдэл болон үүгээр хязгаарлагдахгүйгээр Компанийн нэрийн өмнөөс үйлдвэл зохих аливаа баримт бичгийг үйлдэх, тэдгээрт гарын үсэг зурж баталгаажуулан холбогдох талд хүргүүлэх, хариу хүлээн авах зэрэг бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
8. Гэрээний багц түүнтэй холбогдуулан үйлдсэн аливаа баримт бичгийн хэрэгжилт, Санхүүжилт татан төвлөрүүлэлт болон ашиглалт, холбогдох бусад мэдээллийг Компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр

№ 25/24

Улаанбаатар хот

Гэрээний хугацаа сунгах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4, 9.6.23 дахь заалт болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 24/22 тоот тогтоол, ТУЗ-ийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зээлийн үйл ажиллагааны эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа бөгөөд тус эрэлтийг хангах, өөрийн бүтээгдэхүүнийг зах зээлд үс шаттайгаар нэвтрүүлэхэд эх үүсвэрийн хэрэгцээ байгааг харгалзан Голомт Банктай байгуулсан ЗГС000013613-1/LNFL тоот “Зээлийн гэрээ”-г энэхүү тогтоолын хавсралт №1-д заасан нөхцөлөөр, 2025 оны 04 дүгээр сарын 24-ны өдрөөс эхлэн 1 (нэг) жилийн хугацаатай сунгах зорилгоор Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-ын Голомт Банктай байгуулсан ЗГС000013613-1/LNFL-A тоот “Зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ”-г хүлээн зөвшөөрч, баталгаажуулсугай.
2. Энэхүү тогтоолын 1-т заасантай холбогдуулан Голомт Банктай байгуулсан “Зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ”-ний хэрэгжилтийн талаар Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



ТУЗ-ийн ДАРГА

О.БОЛДВААТАР

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр

№ 25/25

Улаанбаатар хот

Төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагааны бодлого батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1, 76.1.13 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2.10 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.6.17 дахь заалт, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 2.2.29 дэх заалт, Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит хурлын 25/04 тоот шийдвэр болон Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит хурлын 25/04 тоот шийдвэрээр Компанийн дүрмийн 4.2.10 дахь хэсэгт “Төлбөрийн баталгаа гаргах” гэж нэмж, тус чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар шийдвэрлэснийг дурдсугай.
2. Энэхүү тогтоолын 1-т заасантай холбогдуулан Санхүүгийн Зохицуулах Хорооноос “Төлбөрийн баталгаа гаргах” үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл хүсэж, уг зовшоорлийг олгосон тохиолдолд цаашид Компанийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллах “Төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагааны бодлого”-ыг энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагааны бодлого”-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, дагаж мөрдөхийг Компанийн нийт ажилтнуудад үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан бодлоготой холбогдуулан Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх холбогдох бусад бодлого, дүрэм, журам, зааврыг түүнд нийцүүлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд өөрчлөлтийн саналыг Компанийн ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр

№ 25/26

Улаанбаатар хот

Эрсдэлийн удирдлагын бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, 80 дугаар зүйл, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 68 тоот тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 78 тоот “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоол, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дахь заалт болон Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Зохицуулагч байгууллагаас шинэчлэн баталсан журамд Компанийн зохицуулалтын баримт бичиг болон үйл ажиллагааг нийцүүлэх зорилтын хүрээнд Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй “Эрсдэлийн удирдлагын бодлого”-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1-т заасны дагуу нэмэлт, өөрчлөлт орж буй “Эрсдэлийн удирдлагын бодлого”-ыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай.
3. Энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Эрсдэлийн удирдлагын бодлого”-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, дагаж мөрдөхийг Компанийн нийт ажилтнуудад үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан бодлоготой холбогдуулан Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх холбогдох бусад бодлого, дүрэм, журам, зааврыг түүнд нийцүүлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд өөрчлөлтийн саналыг Компанийн ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Б.Оюунболд)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр

№ 25/27

Улаанбаатар хот

Зээл түүнтэй адилтгах активыг ангилах, зээлийн эрсдэлээс хамгаалах сан байгуулах, зарцуулах бодлогод нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, 80 дугаар зүйл, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 68 тоот тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 78 тоот “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоол, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дахь заалт болон Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Зохицуулагч байгууллагаас шинэчлэн баталсан журамд Компанийн зохицуулалтын баримт бичиг болон үйл ажиллагааг нийцүүлэх зорилтын хүрээнд Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй “Зээл түүнтэй адилтгах активыг ангилах, зээлийн эрсдэлээс хамгаалах сан байгуулах, зарцуулах бодлого”-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1-т заасны дагуу нэмэлт, өөрчлөлт орж буй “Зээл түүнтэй адилтгах активыг ангилах, зээлийн эрсдэлээс хамгаалах сан байгуулах, зарцуулах бодлого”-ыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай.
3. Энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Зээл түүнтэй адилтгах активыг ангилах, зээлийн эрсдэлээс хамгаалах сан байгуулах, зарцуулах бодлого”-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, дагаж мөрдөхийг Компанийн нийт ажилтнуудад үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан бодлоготой холбогдуулан Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх холбогдох бусад бодлого, дүрэм, журам, зааврыг түүнд нийцүүлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд өөрчлөлтийн саналыг Компанийн ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Б.Оюунболд)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр

№ 25/28

Улаанбаатар хот

Чанаргүй болон муу активыг зээлийн эрсдэлийн сангаас хорогдуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 68 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын 4.21 дүгээр зүйлийн 4.21.4 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.23 дахь заалт болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компаниас гаргасан саналыг үндэслэн **2,998,230,621.28** (хоёр тэрбум есөн зуун ерэн найман сая хоёр зуун гучин мянга зургаан зуун хорин нэгэн) төгрөгтэй тэнцэх чанаргүй болон муу активыг, тэдгээрт тооцогдсон төлөгдөөгүй шимтгэл болон хүүгийн авлагын төлбөрийн хамт Зээлийн эрсдэлийн сангаас хорогдуулах, түүнтэй холбоотой холбогдох нягтлан бодох бүртгэлийн гүйлгээг 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор хийх эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
2. Зээлийн эрсдэлийн сангаас чанаргүй болон муу активыг хорогдуулах ажиллагааг холбогдох хууль, тогтоомж болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.
3. Зээлийн эрсдэлийн сангаас чанаргүй болон муу активыг хорогдуулах ажиллагааны гүйцэтгэлийг Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр

№ 25/29

Улаанбаатар хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”) -ийн дэргэдэх Аудитын хорооны 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн АХ-25/04 тоот дүгнэлт, ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 24/41 тоот тогтоол болон ТУЗ-ийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани нь шинэ оффист нүүж ирсэнтэй холбогдуулан цаашид ашиглах боломжгүй тавилга, эд хогшлыг ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 24/41 тоот тогтоолын дагуу акталж, худалдан борлуулах үйл ажиллагаа явуулж байгааг дурдсугай.
2. Уг үйл ажиллагааны хүрээнд дараах үнийн дүн, тоо ширхэг бүхий тавилга, эд хогшлыг “ОНДО” ХХК-д худалдах тохиролцоонд хүрээд буйг тэмдэглэсүгэй.

Д/д	Хөрөнгийн төрөл	Анхны өртөг	Үлдэх өртөг	Ашиглаж эхэлсэн огноо	Борлуулах үнэ
1	Буйдан	3,828,000.00	0.00	10/1/2021	800,000.00
2	Гандиан гал тогоо	160,000.00	0.00	3/1/2019	50,000.00
3	Сандал гал тогоо	160,000.00	0.00	3/1/2019	50,000.00
4	Бичгийн ширээ 4 хүний	2,213,880.00	0.00	3/1/2021	1,100,000.00
5	Бичгийн ширээ – 4 хүний	2,213,880.00	0.00	3/1/2021	1,100,000.00
		8,575,760.00	0.00		3,100,000.00

3. “ОНДО” ХХК-тай худалдах, худалдан авах гэрээ байгуулах, гарын үсэг зурж баталгаажуулах, эдгээртэй холбогдох шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
4. Худалдах, худалдан авах гэрээний хэрэгжилт, холбогдох бусад мэдээллийг Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр

№ 25/30

Улаанбаатар хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”) -ийн дэргэдэх Аудитын хорооны 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн АХ-25/05 тоот дүгнэлт, ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 24/41 тоот тогтоол болон ТУЗ-ийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани нь шинэ оффист нүүж ирсэнтэй холбогдуулан цаашид ашиглах боломжгүй тавилга, эд хогшлыг ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 24/41 тоот тогтоолын дагуу акталж, худалдан борлуулах үйл ажиллагаа явуулж байгааг дурдсугай.
2. Уг үйл ажиллагааны хүрээнд дараах үнийн дүн, тоо ширхэг бүхий тавилга, эд хогшлыг “АНД Системс” ХХК-д худалдах тохиролцоонд хүрээд буйг тэмдэглэсүгэй.

Д/д	Хөрөнгийн төрөл	Анхны өртөг	Үлдэх өртөг	Ашиглаж эхэлсэн огноо	Борлуулах үнэ
1	Оффисийн төмөр хөлтэй сандал	260,910.00	0.00	4/26/2024	247,764.00
2	Оффисийн төмөр хөлтэй сандал	260,910.00	0.00	4/26/2024	247,764.00
3	Оффисийн төмөр хөлтэй сандал	260,910.00	0.00	4/26/2024	247,764.00
4	Оффисийн төмөр хөлтэй сандал	260,910.00	0.00	4/26/2024	247,764.00
5	Оффисийн төмөр хөлтэй сандал	260,910.00	0.00	4/26/2024	247,764.00
6	Оффисийн төмөр хөлтэй сандал	260,910.00	0.00	4/26/2024	247,764.00
7	Оффисийн төмөр хөлтэй сандал	260,910.00	0.00	4/26/2024	247,764.00
8	Оффисийн төмөр хөлтэй сандал	260,910.00	0.00	4/26/2024	247,764.00
9	Оффисийн төмөр хөлтэй сандал	260,910.00	0.00	4/26/2024	247,764.00
10	Оффисийн төмөр хөлтэй сандал	260,910.00	0.00	4/26/2024	247,764.00
11	Оффисийн төмөр хөлтэй сандал	260,910.00	0.00	4/26/2024	247,764.00
12	Оффисийн төмөр хөлтэй сандал	260,910.00	0.00	4/26/2024	247,764.00
13	Цагаан нэг хүний ширээ	728,097.00	0.00	1/31/2024	673,485.00
14	Цагаан нэг хүний ширээ	728,097.00	0.00	1/31/2024	673,485.00

15	Цагаан нэг хүний ширээ	728,097.00	0.00	1/31/2024	673,485.00
16	Цагаан нэг хүний ширээ	728,097.00	0.00	1/31/2024	673,485.00
17	Цагаан нэг хүний ширээ	728,097.00	0.00	1/31/2024	673,485.00
18	Цагаан нэг хүний ширээ	728,097.00	0.00	1/31/2024	673,485.00
19	Цагаан нэг хүний ширээ	728,097.00	0.00	1/31/2024	673,485.00
20	Цагаан нэг хүний ширээ	728,097.00	0.00	1/31/2024	673,485.00
21	Цагаан нэг хүний ширээ	728,097.00	0.00	1/31/2024	673,485.00
22	Цагаан нэг хүний ширээ	728,097.00	0.00	1/31/2024	673,485.00
23	Цагаан нэг хүний ширээ	728,097.00	0.00	1/31/2024	673,485.00
24	Цагаан нэг хүний ширээ	728,097.00	0.00	1/31/2024	673,485.00
		11,868,084.00	0.00		11,054,988.00

3. “АНД Системс” ХХК-тай худалдах, худалдан авах гэрээ байгуулах, гарын үсэг зурж баталгаажуулах, эдгээртэй холбогдох шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
4. Худалдах, худалдан авах гэрээний хэрэгжилт, холбогдох бусад мэдээллийг Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр

№ 25/31

Улаанбаатар хот

“ЛэндМН СМЭ ББСБ” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.11, 9.6.23 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 24/43 тоот тогтоол болон ТУЗ-ийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 24/14 тоот тогтоолын дагуу Компанийн “Flexi Business” зээлийн бүтээгдэхүүнийг жижиг, дунд үйлдвэрлэгчдэд санал болгох үйл ажиллагааг хэрэгжүүлэн тогтвортой хөгжлийн зорилтуудыг дэмжих, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, цаашид гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж тогтвортой санхүүжилт, хөрөнгө оруулалтын дэд бүтэц бүрдүүлэх зорилгоор “ЛэндМН СМЭ ББСБ” ХХК (“Охин компани”)-ийг үүсгэн байгуулсныг дурдсугай.
2. Охин компанийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, үйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу эрхлэн явуулах хүрээнд Охин компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг 1,000,000,000 (нэг тэрбум) төгрөгөөр нэмэгдүүлэх шаардлага бий болсныг тэмдэглэсүгэй.
3. Охин компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг өсгөхдөө нэг бүр нь 1,000,000 (нэг сая) төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 1,000 (нэг мянга) ширхэг энгийн хувьцааг нэмж гаргах, Охин компанид хийх хөрөнгө оруулалтыг Компанийн 2024 оны цэвэр ашгаас мөнгөн хөрөнгө хэлбэрээр оруулахаар шийдвэрлэсүгэй.
4. Энэхүү тогтоолын 3-т заасантай холбогдуулан Охин компанийн хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэн аливаа шийдвэр гаргах, баталгаажуулах, Санхүүгийн зохицуулах хороо болон бусад эрх бүхий байгууллагуудад хандах, зөвшөөрөл авах, баримт бичиг бүрдүүлэх ажиллагааг зохион байгуулах зэрэг шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилт, Компанийг төлөөлөн Охин компанийн хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрхэн хэрэгжүүлэн ажиллаж буйтай холбоотой аливаа шийдвэр, үйл ажиллагааг Компанийн ТУЗ-д тогтмол тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр

№ 25/32

Улаанбаатар хот

“ЛэндМН СМЭ ББСБ” ХХК-ийн үйл ажиллагааны чиглэл нэмэхийг зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.11, 9.6.23 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 24/43 тоот тогтоол болон ТУЗ-ийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 24/14 тоот тогтоолын дагуу Компанийн “Flexi Business” зээлийн бүтээгдэхүүнийг жижиг, дунд үйлдвэрлэгчдэд санал болгох үйл ажиллагааг хэрэгжүүлэн тогтвортой хөгжлийн зорилтуудыг дэмжих, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, цаашид гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж тогтвортой санхүүжилт, хөрөнгө оруулалтын дэд бүтэц бүрдүүлэх зорилгоор “ЛэндМН СМЭ ББСБ” ХХК (“Охин компани”)-ийг үүсгэн байгуулсныг дурдсугай.
2. Охин компанийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, цаашид “Flexi Business” зээлийн бүтээгдэхүүнийг Охин компаниас олгох, “Flexi Business” зээлийн бүтээгдэхүүний багцыг Охин компанид шилжүүлэн гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд Охин компанид “Факторингийн үйлчилгээ” эрхлэх тусгай зөвшөөрөл шаардлагатай байгааг тэмдэглэсүгэй.
3. Охин компанийн үйл ажиллагааны чиглэлийг нэмэх буюу Факторингийн үйлчилгээ” эрхлэх тусгай зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос хүсэхээр шийдвэрлэсүгэй.
4. Энэхүү тогтоолын 3-т заасантай холбогдуулан Охин компанийн хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэн аливаа шийдвэр гаргах, баталгаажуулах, Санхүүгийн зохицуулах хороо болон бусад эрх бүхий байгууллагуудад хандах, зөвшөөрөл авах, баримт бичиг бүрдүүлэх ажиллагааг зохион байгуулах зэрэг шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилт, Компанийг төлөөлөн Охин компанийн хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрхэн хэрэгжүүлэн ажиллаж буйтай холбоотой аливаа шийдвэр, үйл ажиллагааг Компанийн ТУЗ-д тогтмол тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

